

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

01.	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2
02.	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай	9
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ		
03.	Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай Дугаар 80	10
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ		
04.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 228	13
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		
05.	Техникийн зохицуулалт батлах тухай Дугаар 380	13
06.	Журам батлах тухай Дугаар 392	18

05.	ᠬᠣᠲ, ᠰᠤᠰᠤᠷᠢᠨᠢ ᠤᠰ ᠬᠠᠨᠭᠠᠮᠵᠢ, ᠠᠷᠢᠭᠤᠲᠠᠬᠤ ᠲᠠᠲᠤᠭᠤᠷᠭᠢᠨ ᠠᠰᠢᠭᠢᠯᠠᠯᠲᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠭᠤᠯᠲᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠤ, ᠪᠡᠷᠴᠢᠯᠡᠯᠲᠤ ᠣᠷᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	᠒
0᠔.	ᠭᠠᠵᠢᠷᠢᠨ ᠲᠣᠰᠨᠢ ᠪᠦᠲᠦᠭᠡᠭᠳᠡᠬᠡᠭᠦᠨᠢ ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠭᠤᠯᠲᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠤ ᠣᠷᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	᠑
0᠔.	ᠵᠡᠪᠯᠡᠯᠡᠳᠦᠬᠡ ᠰᠠᠨᠠᠯ ᠠᠰᠤᠭᠤᠯᠠᠭᠠ ᠶᠠᠪᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	10
04.	ᠡᠯᠴᠢᠨ ᠰᠠᠶᠢᠳᠢᠭᠢ ᠡᠭᠦᠭᠦᠯᠡᠨ ᠲᠠᠲᠠᠬᠤ, ᠲᠣᠬᠣᠣᠨ ᠲᠣᠮᠢᠯᠣᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	13
05.	ᠲᠡᠬᠦᠨᠢᠬᠢᠶᠢᠨ ᠵᠣᠬᠢᠴᠢᠭᠤᠯᠠᠯᠲᠤ ᠪᠠᠲᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	13
06.	ᠵᠢᠷᠠᠮ ᠪᠠᠲᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	18
05.	ᠬᠣᠲ, ᠰᠤᠰᠤᠷᠢᠨᠢ ᠤᠰ ᠬᠠᠨᠭᠠᠮᠵᠢ, ᠠᠷᠢᠭᠤᠲᠠᠬᠤ ᠲᠠᠲᠤᠭᠤᠷᠭᠢᠨ ᠠᠰᠢᠭᠢᠯᠠᠯᠲᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠭᠤᠯᠲᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠤ, ᠪᠡᠷᠴᠢᠯᠡᠯᠲᠤ ᠣᠷᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	᠒
0᠔.	ᠭᠠᠵᠢᠷᠢᠨ ᠲᠣᠰᠨᠢ ᠪᠦᠲᠦᠭᠡᠭᠳᠡᠬᠡᠭᠦᠨᠢ ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠭᠤᠯᠲᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠤ ᠣᠷᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	᠑
0᠔.	ᠵᠡᠪᠯᠡᠯᠡᠳᠦᠬᠡ ᠰᠠᠨᠠᠯ ᠠᠰᠤᠭᠤᠯᠠᠭᠠ ᠶᠠᠪᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	10
04.	ᠡᠯᠴᠢᠨ ᠰᠠᠶᠢᠳᠢᠭᠢ ᠡᠭᠦᠭᠦᠯᠡᠨ ᠲᠠᠲᠠᠬᠤ, ᠲᠣᠬᠣᠣᠨ ᠲᠣᠮᠢᠯᠣᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	13
05.	ᠲᠡᠬᠦᠨᠢᠬᠢᠶᠢᠨ ᠵᠣᠬᠢᠴᠢᠭᠤᠯᠠᠯᠲᠤ ᠪᠠᠲᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	13
06.	ᠵᠢᠷᠠᠮ ᠪᠠᠲᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ	18



Монгол Улс



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.20-3.1.23 дахь заалт:

“3.1.20.“бохир ус” гэж хүн амын ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанаас бий болсон, эсхүл тухайн нутаг дэвсгэрээс хурын ус зайлуулахад үүссэн шингэн хаягдлыг;

3.1.21.“гадаргын ус” гэж хур тунадасны ус хөрсөнд нэвчилгүй, хөрснөөс болон барилга байгууламжийн гаднах гадаргуугаас бохирдсон ус зайлуулах суваг, эсхүл ариутгах татуургын системд шууд зайлуулагдах усыг;

3.1.22.“лаг” гэж төрөл бүрийн хаягдал уснаас энгийн болон механик аргаар ялган авсан ус ба хатуу хольцын холимгийг;

3.1.23.“индексжүүлэлт” гэж цэвэр, бохир усны үйл ажиллагааны зардлын үндсэн хүчин зүйлсийн бодит өөрчлөлтөөс хамааруулан тооцож зохицуулахыг.”

2/5 дугаар зүйлийн 5.1.8, 5.1.9 дэх заалт:

“5.1.8.гадаргын болон хөрсний ус зайлуулах системийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, холбогдох дүрэм, журмыг батлах;

5.1.9.лагийг тээвэрлэх, боловсруулах, ашиглах, устгахтай холбоотой журам, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;”

3/8 дугаар зүйлийн 8.1.4-8.1.7 дахь заалт:

“8.1.4.ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг хот, суурины ус хангамж,



ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн томилж, чөлөөлөх;

8.1.5.унд, ахуйн хэрэглээний усны аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн стандартыг мөрдүүлэх;

8.1.6.тухайн нутаг дэвсгэрт цэвэр, бохир усны шугам сүлжээний хамгаалалтын зурваст баригдсан барилга байгууламж, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, эдгээр зөрчлийг гаргуулахгүй байх арга хэмжээг авах;

8.1.7.нүхэн жорлонгийн тоог бууруулах ажлыг зохион байгуулах;”

4/10 дугаар зүйлийн 10.1.9-10.1.12 дахь заалт:

“10.1.9.зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлал баталж, хэрэгжүүлэх;

10.1.10.гадаргын болон хөрсний усыг ариутгах татуургын системд нийлүүлэх төлбөрийн хэмжээг тогтоох;

10.1.11.бусдын эзэмшлийн шугам сүлжээ, дамжуулан шахах насосын станцаар цэвэр ус түгээх, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах нөхцөлд хангагч, шугам сүлжээ эзэмшигчдийн хооронд хийх төлбөр тооцооны журам батлах;

10.1.12.энэ хуулийн 3.1.14-т заасан хангагчийн үйлчлэх хүрээг тогтоох журам батлах;”

5/18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг:

“18.7.Нийтэд халдварлах аюултай нян, бактери, химийн нэгдлийн бохирдол бүхий хаягдал бохир усыг энэ хуулийн 18.1-д заасан зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа бохир ус татан зайлуулах шугам сүлжээнд нийлүүлэх бөгөөд уг үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага хариуцна.”

6/20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг:

“20.4.Энэ хуулийн 20.1-д заасан цэвэр усны хэмжээ нь хэрэглэсэн халуун, хүйтэн усны хэмжээтэй тэнцүү байх бөгөөд бохир усны хэмжээ нь Зохицуулах хорооны тогтоосноос өөрөөр заагаагүй бол цэвэр усны хэмжээтэй тэнцүү байна.”

2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.19 дэх заалт:

“3.1.19. “саарал ус” гэж ямар нэгэн ялгадасгүй зөвхөн ахуйн бохир усыг;”

2/8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт:

“8.1.2. нутаг дэвсгэрийнхээ ус хангамж, ариутгах татуурга, гадаргын ус зайлуулах барилга байгууламжийг төлөвлөх талаар төсөл, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах;”

3/9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэг:

“9.10. Зохицуулах хороо жил бүр тухайн жилийн үйл ажиллагааны төсвөө баталж, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тайлагнана.”

4/10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт:

“10.1.1. цэвэр, бохир усны үйлчилгээний тарифын бүтцийг тодорхойлох, тариф тогтоох аргачлал, төлбөр тооцох журам, цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх;”

5/15 дугаар зүйлийн 15.1.13 дахь заалт:

“15.1.13. усны хэрэглээний төлбөрөө энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан хэмжээнд үндэслэн төлөх.”

3 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн гарчиг, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.9, 9.12, 9.13, 9.14 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн гарчиг, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.11 дэх заалтын “зохицуулах зөвлөлийн” гэснийг “Зохицуулах хорооны” гэж, гуравдугаар бүлгийн гарчиг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.7, 9.8, 9.11, 9.13 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “зохицуулах зөвлөл” гэснийг “Зохицуулах хороо” гэж, 9 дүгээр зүйлийн 9.15 дахь хэсгийн “Зохицуулах зөвлөлд” гэснийг “Зохицуулах хороонд” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.18 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Зохицуулах зөвлөлөөс” гэснийг “Зохицуулах



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 4, 5 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг явуулсугай.

2.Төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн оролцоог хангах, мэдлэг мэдээлэл олгох, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Зөвлөлдөх санал асуулгыг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулсугай. Энэ хүрээнд зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотод Төрийн ордны “Их танхим”-д явуулахаар тогтсугай.

3.Зөвлөлдөх санал асуулгын үйл ажиллагаанд шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэх хугацааг 2022 оны 12 дугаар сарын 23-наас 12 дугаар сарын 30-ны өдрөөр товлон тогтоосугай.

5.Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох ажлын хэсгийг байгуулах, Зөвлөлдөх зөвлөлийн үйл ажиллагаанд зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Мөнхбат/, Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т үүрэг болгосугай.

6.Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах ажлын хүрээнд:

1/“Нийгэм, улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудал: “Гарц шийдэл”” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахыг Монгол Улсын Шинжлэх ухааны академи /Д.Рэгдэл/, Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т;



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 228

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Оманы Султант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зоригтын Чинтүшигийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Оманы Султант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Энхтүвшингийн Булганыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 10 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 380

Улаанбаатар
хот

Техникийн зохицуулалт батлах тухай

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Техникийн зохицуулалтыг мөрдүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттайгаар авч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Стандарт, хэмжил зүйн газар (Б.Билгүүн)-т тус тус үүрэг болгосугай.



3. Техникийн зохицуулалтыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Х.БОЛОРЧУЛУУН

Засгийн газрын 2022 оны 380 дугаар
тогтоолын хавсралт

**ЯМААНЫ НООЛУУРЫН БОЛОВСРУУЛАЛТ, ХУДАЛДААНД
МӨРДӨХ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын зорилго нь ямааны ноолуурын боловсруулалт, худалдааны явцад хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх, техникийн зохицуулалтын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхээс хамгаалахад оршино.

1.2.Энэ техникийн зохицуулалтыг ямааны боловсруулсан ноолуурыг улсын хилээр нэвтрүүлэхээр мэдүүлэх, хорио цээрийн хяналт, шалгалт хийх үйл ажиллагаанд баримтална.

1.3.Энэ техникийн зохицуулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа ноолуур боловсруулах болон худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээд заавал дагаж мөрдөнө.

1.4.Энэ техникийн зохицуулалтад эш татаж хэрэглэсэн дараах стандарт, баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж хэрэглэнэ:

1.4.1.MNS 3683 Ноос, ноолуур. Ямааны боловсруулсан ноолуур. Техникийн шаардлага (4.1, 5.1 дүгээр зүйл);

1.4.2.MNS 5563 Ноос боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага;

1.4.3.MNS 6390 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага;

1.4.4.ISO 14001 Байгаль орчны удирдлагын тогтолцоо;

1.4.5.MNS 0215 Бүх төрлийн ноосон ширхэгт материалыг савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх журам. Техникийн шаардлага;

1.4.6.MNS 4244 Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага;

1.4.7.MNS 4930 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага;

1.4.8.MNS 5002 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага;

1.4.9.MNS 5029 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт бодисын шошго, тэмдэглэгээ.

1.5.Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1.боловсруулсан ноолуур (dehaired cashmere) гэж угаасан ноолуурыг үйлдвэрийн аргаар самнаж, хялгасыг нь ялгасан ноолуурыг;

1.5.2.туузалсан ноолуур (cashmere tops) гэж хялгасыг ялгасан ноолуурыг самнаж цувин тууз хэлбэрт оруулж, бөмбөглөн ороосон ноолуурыг;

1.5.3.ноолуурын бүрэлдэхүүн (content of cashmere):

1.5.3.1.хялгас үс (coarse hair) гэж хөндий голтой, бүүдүүн, урт, хөшүүн ширхэгтийг;

1.5.3.2.завсрын үс (intermediate hair) гэж тасалдсан хөндий голтой, хялгас үснээс нарийн, урт, том долгион атираатай ширхэгтийг;

1.5.3.3.ноолуур үс (down hair) гэж хөндий голгүй, нарийн, богино, олон тооны жижиг атираатай зөөлөн ширхэгтийг.



Хоёр.Ноолуур боловсруулах, худалдаалахад тавигдах шаардлага

2.1.Ямааны ноолууран түүхий эдийг “MNS 0038 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Ямааны ноолуур. Техникийн шаардлага” стандартын дагуу бэлтгэнэ.

2.2.Түүхий эдийн гарал үүслийг орон нутгийн эрх бүхий байгууллага тодорхойлно.

2.3.Ямааны боловсруулсан ноолуур нь “MNS 3683 Ноос, ноолуур. Ямааны боловсруулсан ноолуур. Техникийн шаардлага” стандартыг хангасан байна.

2.4.Үйлдвэрлэгч нь энэ техникийн зохицуулалтын 2.3-т заасан стандартын дагуу боловсруулсан ноолуурт чанарын баталгаа гарган, лабораторийн шинжилгээний дүнг дагалдуулна.

2.5.Экспорт, импортын зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэх ямааны ноолуур нь дараах шаардлагыг хангасан байна:

2.5.1.хялгас болон завсрын үсний агууламж 0.3 хувиас ихгүй;

2.5.2.тослог 1.0 хувиас ихгүй;

2.5.3.чийглэг 17 хувиас ихгүй.

2.6.Ямааны сэв хялгас (MNS 4251) болон зумласан ноолуур (MNS 5251)-т энэ техникийн зохицуулалтын 2.5 дахь заалт хамаарахгүй.

2.7.Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулж гадаад оронд худалдаалахаар гаргаж байгаа ямааны ноолуурыг захиалагчтай тохирсон гэрээнд заасны дагуу баглаж, хаяглан тээвэрлэнэ.

Гурав.Ноолуурын үйлдвэрт тавигдах шаардлага

3.1.Экспортод гаргах ноолууран түүхий эдийг “MNS 5563-2005. “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага” стандартын шаардлага хангасан, албан ёсны зөвшөөрөлтэй Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрт боловсруулсан байна.

3.2. Үйлдвэрийн барилга, байгууламжийн байршил, зам талбай нь үйлдвэрлэлийн технологийн урсгал, боловсруулалтын үе шатны дарааллыг баримталсан байна.

3.3. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандартын хүрээнд хөдөлмөр хамгаалал, техникийн болон галын аюулгүй ажиллагаа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэлийн технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн үндсэн шаардлагыг хангасан байх ба “MNS 6390, Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага” стандартыг мөрдөнө.

3.4. Үйлдвэрлэлийн процесс, үйл ажиллагааг мэргэжлийн инженер-технологичийн удирдлага дор явуулсан байна.

3.5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэж, орчны хяналт-шинжилгээний график, хөтөлбөртэй байна.

3.6. Үйлдвэр нь технологийн горимыг хянах, түүхий эд, үндсэн туслах материалын чанарт шинжилгээ хийх өндөр нарийвчлал бүхий багаж тоног төхөөрөмжөөр тоноглогдсон дотоод хяналт-шинжилгээний лабораторитой байна.

Дөрөв. Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд хяналт хийхэд тавигдах шаардлага

4.1. Ямааны ноолуурыг худалдаалах зорилгоор улсын хилээр нэвтрүүлэхэд холбогдох хууль тогтоомж, зааврын дагуу хяналт шалгалт хийнэ.

4.2. Экспортод гаргах ямааны ноолууран түүхий эдийг тохирлын баталгаанд хамруулна.

4.3. Ямааны ноолуурыг Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулж, экспортлох зорилгоор хилээр нэвтрүүлэх мэдүүлэгт холбогдох хууль тогтоомжид заасан баримт бичгийг хавсаргасан байна.

4.4. Энэ техникийн зохицуулалтын хэрэгжилтэд холбогдох мэргэжлийн хяналт хэрэгжүүлэх байгууллага хяналт тавина.

---o0o---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 392

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

Засгийн газрын 2022 оны 392 дугаар
тогтоолын хавсралт

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ТӨЛӨӨЛЛИЙН БОЛОН ЯАРАЛТАЙ ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ҮНДЭСНИЙ ЖАГСААЛТАД БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.4-т заасан соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад (цаашид “үндэсний жагсаалт” гэх) бүртгэх үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Монголын ард түмний уламжлалт мэдлэг, арга ухаан, сэтгэлгээний илэрхийлэл болсон түүх, соёл, урлаг, гоо зүйн болон шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдолтой соёлын биет бус өвийг төлөөллийн үндэсний жагсаалтад бүртгэнэ.

1.3.Оролцогч талуудын хүчин чармайлтаас үл хамааран өвийн оршин тогтнох чадвар нь устах, мартагдах аюулд орж, яаралтай хамгаалах хэрэгцээ, шаардлага үүссэн бол яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэнэ.

Хоёр.Үндэсний жагсаалтад нэр дэвшүүлэх санал

2.1.Монгол Улсын иргэн, бүлэг хүн, хамт олон (цаашид “иргэн” гэх), хуулийн этгээд соёлын биет бус өвийг үндэсний жагсаалтад нэр дэвшүүлэх санал (цаашид “санал” гэх)-ыг Соёлын өвийн үндэсний төвд гаргана.

2.2.Үндэсний жагсаалтад нэр дэвшүүлэх соёлын биет бус өв нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.1.4-т заасан улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй байна.

2.3.Энэ журмын 2.1-д заасан иргэн, хуулийн этгээдийн санал дараах бүрдэлтэй байна:

2.3.1.саналын үндэслэлийг тодорхой дурдсан өргөдөл, эсхүл албан бичиг;

2.3.2.тухайн өвийг өвлөн уламжилсан 3-аас доошгүй өвлөн уламжлагчийн санал (бичиг, дуу-дүрсний болон дууны бичлэг байж болох);

2.3.3.өвийг илэрхийлэх гэрэл зураг, эсхүл дүрс бичлэг, холбогдох баримт бичиг.

2.4.Соёлын өвийн үндэсний төв саналын бүрдлийг ажлын 7 хоногт багтаан хянана. Энэ журмын 2.3-т заасан бүрдэл дутуу саналыг зөвлөмжийн хамт иргэн, хуулийн этгээдэд буцаана.

2.5.Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 2.3-т заасан бүрдэл хангасан саналын дагуу соёлын биет бус өвийн төлөв байдалд дараах шалгуурын дагуу журмын 2.6-д заасан хөндлөнгийн шинжээчээр үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулна:

2.5.1.үүсэл хөгжил, хувирал өөрчлөлт, уламжлал шинэчлэлийг илэрхийлэх эх сурвалжийн баялаг байдал;

2.5.2.бусад өвийн төрөл зүйлээс ялгарах онцлог шинж, тархалт;

2.5.3.оршин тогтнох чадвар болон оролцогч талуудын өвийг хамгаалах чиглэлээр гаргаж байгаа хүчин чармайлт.

2.6.Хөндлөнгийн шинжээч нь соёлын биет бус өвийн чиглэлээр мэргэшсэн, эрдмийн зэрэг, цолтой, Монгол Улсын иргэн, эсхүл мэргэжлийн төрийн бус байгууллага байна.



2.7. Үнэлгээ хийх аргачлалыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.8. Үнэлгээг ажлын 7 хоногт багтаан зохион байгуулна.

2.9. Соёлын өвийн үндэсний төв хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтэд үндэслэсэн саналыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн бол дор дурдсан байгууллагаас ажлын 7 хоногт багтаан санал авч хавсаргана:

2.9.1. соёл, урлагийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

2.9.2. Шинжлэх ухааны академи;

2.9.3. өв оршин байгаа аймаг, нийслэлийн Засаг дарга;

2.9.4. ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс;

2.9.5. холбогдох мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага;

2.9.6. холбогдох бусад эрдэм шинжилгээний байгууллага.

2.10. Соёлын өвийн үндэсний төв үндэсний жагсаалтад нэр дэвшүүлэх саналыг энэ журмын хавсралтаар баталсан маягтын дагуу үйлдэж, энэ журмын 2.1, 2.5, 2.9-д заасан баримт бичгийн хамт соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.11. Саналыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх шаардлагагүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухай санал гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын 7 хоногт багтаан хүргүүлнэ.

Гурав. Саналыг хянан шийдвэрлэх

3.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага саналыг хүлээн авч, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөл (цаашид “Мэргэжлийн зөвлөл” гэх)-өөр ажлын 10 хоногт багтаан хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулах арга хэмжээ авна.

3.2. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн соёлын биет бус өвийг үндэсний жагсаалтад бүртгүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.



3.3.Нэр дэвшүүлсэн өв энэ журамд заасан шаардлагыг хангаагүй тухай Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарсан бол холбогдох баримт бичгийг тайлбарын хамт ажлын 5 хоногт багтаан Соёлын өвийн үндэсний төвд буцаан хүргүүлнэ.

3.4.Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 3.3-т заасан тайлбар, баримт бичгийг ажлын 5 хоногт багтаан санал гаргасан иргэн, хуулийн этгээдэд хүргүүлнэ.

Дөрөв.Төлөв байдлын үнэлгээ

4.1.Соёлын өвийн үндэсний төв 3 жил тутам үндэсний жагсаалтад бүртгэсэн соёлын биет бус өвийн төлөв байдалд энэ журмын 2.7-д заасан аргачлалын дагуу хөндлөнгийн шинжээчээр үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулна.

4.2.Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 4.1-д заасан шинжээчийн дүгнэлтэд үндэслэн яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэсэн соёлын биет бус өвийн оршин тогтнох чадвар нь тогтворжсон бол төлөөллийн үндэсний жагсаалтад, төлөөллийн үндэсний жагсаалтад бүртгэсэн соёлын биет бус өвийн оршин тогтнох чадвар нь доройтож, устах, мартагдах аюулд орсон бол яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад шилжүүлэх саналыг боловсруулж, энэ журмын 2.10-д заасны дагуу соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3.Соёлын биет бус өвийг үндэсний жагсаалт хооронд шилжүүлэх саналд энэ журмын 2.9-д заасан байгууллагуудаас санал авч, хавсаргасан байна.

4.4.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын биет бус өвийг үндэсний жагсаалт хооронд шилжүүлэх асуудлыг энэ журмын 3.1-3.3-т заасны дагуу зохион байгуулна.

Тав.Бусад зүйл

5.1.Үндэсний жагсаалтад бүртгэсэн соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах ажлыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүх шатны Засаг дарга, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулна.

5.2.Соёлын өвийн үндэсний төв болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь соёлын биет бус өвийг үндэсний жагсаалтад нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүр цахим хуудаст нээлттэй, ил тод байрлуулна.



5.3.Үндэсний жагсаалтад нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудаст нээлттэй, ил тод байрлуулах нь хувь хүн, бүлэг хүн, хамт олны эрх ашигт сөргөөр нөлөөлөх бол албан бичгээр гаргасан хүсэлтийн дагуу тэдний алдар нэр, бусад мэдээллийг нууцалж болно.

5.4.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

---o0o---

Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журмын хавсралт

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ТӨЛӨӨЛЛИЙН БОЛОН ЯАРАЛТАЙ ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ҮНДЭСНИЙ ЖАГСААЛТАД НЭР ДЭВШҮҮЛЭХ МАЯГТ

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ			
Соёлын биет бус өвийн нэр:			
Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн дугаар:			
Нэр дэвшүүлсэн иргэн, хуулийн этгээдийн нэр, оршин суугаа газрын хаяг:			
Нэр дэвшүүлж буй үндэсний жагсаалтын нэр:	Төлөөллийн	Яаралтай хамгаалах шаардлагатай	
2.ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ			
Өгөгдлийн нэр:	Тайлбар мэдээлэл	Үнэлгээний илэрхийлэл	
Соёлын биет бус өвийн үүсэл хөгжил, хувьсал өөрчлөлт, уламжлал шинэчлэлийг илэрхийлэх эх сурвалжийн баялаг байдал		Хангалттай	Хангалтгүй



Соёлын биет бус өвийн бусад өвөөс ялгарах онцлог шинж, тархалт		Хангалттай	Хангалтгүй	
Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадвар ба өвийг хамгаалахад гаргаж буй оролцогч талуудын хүчин чармайлт		Хангалттай	Хангалтгүй	
3.БАЙГУУЛЛАГЫН САНАЛ				
Байгууллагын нэр:	Тайлбар мэдээлэл	Саналын илэрхийлэл		
Соёл, урлагийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага		Дэмжсэн	Дэмжээгүй	
Шинжлэх ухааны академи		Дэмжсэн	Дэмжээгүй	
Аймаг, нийслэлийн Засаг дарга		Дэмжсэн	Дэмжээгүй	
ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс		Дэмжсэн	Дэмжээгүй	
Холбогдох мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага		Дэмжсэн	Дэмжээгүй	
Холбогдох бусад эрдэм шинжилгээний байгууллага		Дэмжсэн	Дэмжээгүй	
4.БАТАЛГААЖУУЛАЛТ				
Маягт үйлдсэн:	Соёлын өвийн үндэсний төвийн захирал	Нэр	Гарын үсэг	Огноо
	Хөндлөнгийн шинжээч	Нэр	Гарын үсэг	Огноо
	Бүрдүүлэлт хийсэн ажилтан	Нэр	Гарын үсэг	Огноо

---o0o---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 200003